



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/В0

Улаанбаатар хот

**MNS ISO 9001:2016 Чанарын
удирдлагын тогтолцоог байгууллагад
нэвтрүүлэх, хэрэгжүүлэх зөвлөх баг
томилон ажиллуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.2, 6.8.3, 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Институт нь түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн нийслэлийн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж нийслэл хотын удирдлага, хот байгуулалтын салбарын байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг олон улсын жишигт нийцсэн хот төлөвлөлтийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, зураг төслөөр хангах эрхэм зорилго, байгууллагын бодлого, зорилтод хүрэхэд шаардагдах үйл явц болон нөөцийг тодорхойлох үйл ажиллагаа буюу MNS ISO 9001:2016 Чанарын удирдлагын тогтолцоог байгууллагад нэвтрүүлсүгэй.

2. Байгууллагын чанарын бодлого, чанарын зорилгыг тодорхойлох, чанарын зорилгод хүрэхэд шаардлагатай ажилбар, арга хэмжээг тогтоох, хэрэгжүүлэх, нөөцийг илрүүлэх, бэлтгэх, MNS ISO 9001:2016 Чанарын удирдлагын тогтолцоог байгууллагад нэвтрүүлэх зөвлөх багийг хавсралтад нэр дурдснаар томилон ажиллуулсугай.

3. Байгууллагад Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, 2022 оны 07 дугаар сард багтаан батлуулж, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж, биелэлт, үр дүнг тухай бүр захиргааны зөвлөлийн хуралд хэлэлцүүлж ажиллахыг зөвлөх баг (Г.Уранбайгал)-д даалгасугай.

4. Энэ тушаалын биелэлтийг хангаж ажиллахад шаардагдах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Институтийн 2022 оны үйл ажиллагааны бусад зардлаас гаргахыг нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д даалгасугай.

ДАРГА



С.ОЧИР-ЭРДЭНЭ

3150600225